



**МОНГОЛБАНК**  
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

**ГАДААД СЕКТОРЫН  
СТАТИСТИК**

Танилцуулга  
2020 оны 1 дүгээр улирал

Улаанбаатар  
2020




### 1. Төлбөрийн тэнцэл

Урсгал ба хөрөнгийн данс 2020 оны 1 дүгээр улиралд 651 сая ам.долларын алдагдалтай, санхүүгийн данс 320 сая ам.долларын ашигтай, нийт төлбөрийн тэнцэл 350 сая ам.долларын алдагдалтай гарлаа. Статистикийн алдаа ба орхигдуулгын дүн -19 сая ам.доллар байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад урсгал ба хөрөнгийн дансны алдагдал 278 сая ам.доллараар өсч, санхүүгийн дансны ашиг 237 сая ам.доллараар буурсан үзүүлэлттэй байна.

Гадаад валютын улсын нөөц тайлант улирлын эцсийн байдлаар 4,094 сая ам.доллар буюу сүүлийн 3 сарын дунджаар тооцсон импортын 12.6 сарын хэрэгцээг хангах түвшинд байна.

Дүрслэл 1. Төлбөрийн тэнцэл (сая ам.доллар)




### Барааны худалдаа

Төлбөрийн тэнцлийн аргачлалаар тооцсон барааны худалдааны эргэлт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 32%-аар буурч 1,999 сая ам.долларт хүрч, худалдааны тэнцэл 277 сая ам.долларын алдагдалтай гарсан.

Тодруулбал, экспортын хувьд, чулуун нүүрсний экспорт 389 сая ам.доллараар (61%), зэсийн баяжмал 153 сая ам.доллараар (30%), мөнгөжөөгүй алт 116 сая ам.доллараар (59%), СИФ нөхцөлөөр тооцсон хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 63 сая ам.доллараар (12%), хэрэглээний бүтээгдэхүүний импорт 32 сая ам.доллараар (9%), нефтийн бүтээгдэхүүний импорт 28 сая ам.доллараар (11%) тус тус буурсан. Улмаар барааны тэнцэл өнгөрсөн оны мөн үеэс 612

сая ам.доллараар буурчээ.


Дүрслэл 2. Барааны худалдаа (сая ам.доллар)



### Үйлчилгээний худалдаа


2020 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр үйлчилгээний худалдааны алдагдал өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 52%-аар буюу 339 сая ам.доллараар буурч, 308 сая ам.долларт хүрсэн. Үүнд бизнесийн бусад үйлчилгээний алдагдал 144 сая ам.доллар, тээврийн үйлчилгээний алдагдал 104 сая ам.доллар, санхүүгийн үйлчилгээний алдагдал 56 сая ам.доллараар тус тус буурсан нь голлон нөлөөлсөн байна (Дүрслэл 3).

Дүрслэл 3. Үйлчилгээний худалдаа (сая ам.доллар)




Үйлчилгээний экспорт өмнөх оны мөн үеэс 8%-аар буюу 16 сая ам.доллараар буурч 173 сая ам.долларт хүрчээ. Үүний 59% буюу 102 сая ам.долларыг тээвэр, 19% буюу 32 сая ам.долларыг бизнесийн бусад үйлчилгээ, 12% буюу 20 сая ам.долларыг аялал жуулчлалын үйлчилгээний экспортын орлого бүрдүүлж байна.

Дүрслэл 4. Үйлчилгээний экспорт (сая ам.доллар)



Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад үйлчилгээний импорт 42%-аар буюу 355 сая ам.доллараар буурч, 480 сая ам.долларт хүрсэн ба үүнээс 41%-ийг буюу 195 сая ам.долларыг аялал жуулчлал, 28%-ийг буюу 133 сая ам.долларыг тээвэр, 14%-ийг буюу 66 сая ам.долларыг бизнесийн бусад, 6%-ийг буюу 28 сая ам.долларыг харилцаа холбооны үйлчилгээ авахад тус тус зарцуулжээ.

Дүрслэл 5. Үйлчилгээний импорт (сая ам.доллар)




### Аялал жуулчлалын үйлчилгээ

Сүүлийн 4 жилийн дунджаар аялал жуулчлалын үйлчилгээний дансны орлого нь манай улсын нийт үйлчилгээний экспортын 39%-ийг, зарлага нь нийт үйлчилгээний импортын 28%-ийг бүрдүүлсэн байна.


Тэгвэл аялал жуулчлалын үйлчилгээний салбарын орлогын 21%-ийг БНСУ, 19%-ийг БНХАУ, 12%-ийг ОХУ, 5%-ийг Япон, 33%-ийг бусад улсын аялагчдад үзүүлсэн үйлчилгээнээс хүлээн авсан байна.

Дүрслэл 6. Аялалын үйлчилгээний экспорт, 2017-2020.I (сая ам.доллар)



Харин аялал жуулчлалын салбарын импортыг улсаар нь ангилбал: Монгол улсын иргэд нийт зардлын тус бүр 19%-ийг Япон болон БНСУ-д, 10%-ийг Герман, 7%-ийг ОХУ, 6%-ийг БНХАУ-д аялахдаа зарцуулсан байна.


Дүрслэл 7. Аялалын үйлчилгээний импорт, 2017-2020.I (сая ам.доллар)



### Анхдагч орлого

Анхдагч орлогын данс 163 сая ам.долларын алдагдалтай гарч, алдагдлын хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 43%-аар буюу 125 сая ам.доллараар буурсан үзүүлэлтэй байна. Үүнд хөрөнгө оруулалтын орлогын дансны алдагдал голчлон нөлөөлсөн. Тайлант улиралд манай улс гадаад бонд, үнэт цаасны хүүгийн төлбөрт 102 сая ам.доллар, ногдол ашигт 34 сая ам.доллар, шууд хөрөнгө оруулагчийн зээлийн хүүгийн төлбөрт 132 сая ам.доллар, бусад зээлийн хүүгийн төлбөрт 55 сая ам.доллар, харьяат бусын эзэмшиж буй харилцах, хадгаламжийн дансны хүүгийн төлбөрт 0.1 сая ам.долларыг тус тус төлсөн байна.

Дүрслэл 8. Анхдагч орлого (сая ам.доллар)



**Хоёрдогч орлого**

Хувийн гуйвуулга болон хандив тусламжийн шугамаар 2020 оны 1 дүгээр улиралд Монгол улс нийт 79 сая ам.долларыг буюу өнгөрсөн оны мөн үеэс 5 сая ам.доллараар их орлого хүлээн авчээ. Үүнд:

- Гадаадад ажиллаж, амьдарч буй Монгол иргэдээс хүлээн авсан мөнгөн гуйвуулга өмнөх оноос 6%-аар, харин гадаад руу шилжүүлсэн мөнгөн гуйвуулга 5%-аар тус тус буурсан байна.
- Хандив тусламжийн орлого өмнөх оны мөн үеэс 7 сая ам.доллараар өссөн байна.

Хүснэгт 1. Хувийн гуйвуулга 2020.I (мян ам.доллар)

	Хүлээн авсан			Шилжүүлсэн		
	Дүн	Хувь	Өсөлт	Дүн	Хувь	Өсөлт
Солонгос	23,718	43% ▼	-24%	4,632	16% ▼	-7%
Америк	2,820	5% ▼	-39%	4,631	16% ▲	10%
Хятад	294	1% ▲	22%	902	3% ▼	-26%
Гонг Конг	618	1% ▼	-13%	234	1% ▼	-51%
Англи	9,573	17% ▲	1532%	1,677	6% ▼	-15%
ОХУ	8,313	15% ▼	-9%	2,457	9% ▲	13%
Сингапур	1,043	2% ▲	8%	888	3% ▼	-40%
Швейцарь	770	1% ▼	-35%	218	1% ▲	21%
Герман	1,240	2% ▼	-21%	531	2% ▼	-17%
Япон	406	1% ▼	-50%	692	2% ▼	-28%
Бусад	6,770	12% ▼	-23%	11,932	41% ▼	-25%
<b>НИЙТ</b>	<b>55,565</b>	<b>100%</b>		<b>28,794</b>	<b>100%</b>	

**Гадаадын шууд хөрөнгө оруулалт**

2020 оны 1 дүгээр улиралд Монгол улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгалын дүн 607 сая ам.доллар, харин хөрөнгө оруулалтын буцаалт болон зээлийн эргэн төлөлттэй холбоотой гарах урсгал 230 сая ам.доллар буюу цэвэр дүнгээр 377 сая ам.долларын орох урсгалтай байв.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгалыг өмнөх оны мөн үеийн гүйцэтгэлтэй харьцуулбал 4 сая ам.доллараар буурсан дүнтэй байна.

Шууд хөрөнгө оруулалтын орох урсгалыг голлох улсаар нь харвал:

- Канад улсаас орж ирсэн хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеэс 46 сая ам.доллараар өсч, 440 сая ам.доллар,
- АНУ-аас орж ирсэн хөрөнгө оруулалт 8 сая ам.доллараар өсч, 18 сая ам.доллар,
- БНХАУ-аас ирсэн хөрөнгө оруулалт 37 сая ам.доллараар буурч, 24 сая ам.доллар,
- Япон улсаас орж ирсэн хөрөнгө оруулалт 13 сая ам.доллараар буурч, 20 сая ам.долларын орох урсгалтай байсан байна.

Хүснэгт 2. ГШХО, орох урсгал, улсаар (сая ам.доллар)

№	Үзүүлэлт	2020		2020.I/19.I	
		Дүн	Хувь	Өөрчлөлт	
1	Австрали	3	1%	-4	▼
2	АНУ	18	3%	8	▲
3	Англи	12	2%	-5	▼
4	БНХАУ	24	4%	-37	▼
5	Герман	5	1%	4	▲
6	Нидерланд	4	1%	2	▲
7	Хонг-Конг	6	1%	-1	▼
8	Канад	440	72%	46	▲
9	Люксембург	10	2%	-9	▼
10	ОХУ	5	1%	-7	▼
11	Сингапур	36	6%	7	▲
12	Солонгос (өмнөд)	3	1%	0	▲
13	Турк	0	0%	0	▲
14	Франц	1	0%	-1	▼
15	Япон	20	3%	-13	▼
16	Бусад	20	3%	7	▲
	<b>Нийт</b>	<b>607</b>	<b>100%</b>	<b>-4</b>	<b>▼</b>

Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзвэл:

- Барилгын салбарт орж ирсэн хөрөнгө оруулалт 13 сая ам.доллараар,
- Мэргэжлийн, шинжлэх ухаан болон технологийн үйл ажиллагааны салбар 9 сая ам.доллараар тус тус өссөн бол,
- Уул уурхайн салбар 10 сая ам.доллараар,
- Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбар 9 сая ам.доллараар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 3. ГШХО, орох урсгал, салбараар (сая ам.доллар)

№	Эдийн засгийн салбар	I улирал		2020.I/19.I
		2019	2020	Өөрчлөлт
1	Барилга	9	23	13 ▲
2	Боловсрол	0	0	0 ▼
3	Боловруулах үйлдвэрлэл	5	4	-2 ▼
4	Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ	32	27	-4 ▼
5	Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	1	0	-1 ▼
6	Мэдээлэл, холбоо	2	3	1 ▲
7	Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	4	13	9 ▲
8	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	28	28	0 ▼
9	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	9	5	-4 ▼
10	Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл	17	8	-9 ▼
11	Уул уурхай, олборлолт	487	476	-10 ▼
12	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	12	13	1 ▲
13	Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	3	6	3 ▲
14	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан	0	1	0 ▲
15	Цахилгаан, хий, уур, агааржуулалт	0	0	0 ▼
16	Бусад	0	0	0 ▼
<b>Нийт</b>		<b>611</b>	<b>607</b>	<b>-4</b> ▲


### Багцын хөрөнгө оруулалт

Багцын хөрөнгө оруулалтын данс 2020 оны 1 дүгээр улиралд 51 сая ам.долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад ашиг 291 сая ам.доллараар буурсан.

Тайлант улирлын голлох ажил гүйлгээг дурдвал:

- Хуралдай бондын хүүгийн төлбөрт 26 сая ам.доллар,
- МИК300 бондын хүүгийн төлбөрт 15 сая ам.долларыг эдийн засгийн харьяат буст төлсөн байна.

Дүрслэл 9. Багцын хөрөнгө оруулалт (сая ам.доллар)




### Бусад хөрөнгө оруулалт

Энэ дансанд өмнөх санхүүгийн дансуудад үл хамаарах бусад хөрөнгө оруулалтууд, үүнд, арилжааны болон хөнгөлөлттэй нөхцөлтэй зээлүүд, худалдааны зээллэг зэрэг бүх төрлийн зээлүүд, бэлэн мөнгө ба харилцах хадгаламжийн дансны эх үүсвэрийг бүртгэдэг.

2020 оны 1 дүгээр улиралд бусад хөрөнгө оруулалтын данс цэвэр дүнгээр 97 сая ам.долларын гарах урсгалтай байсан бөгөөд

үүнийг өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулбал, 169 сая ам.доллараар сайжирсан үзүүлэлт юм. Энэ өөрчлөлтөд арилжааны банкуудын зээлийн ашиглалт болон худалдааны зээлийн санхүүжилт өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Дүрслэл 10. Бусад хөрөнгө оруулалт



## 2. Гадаад хөрөнгө оруулалтын позиц

Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын позиц 2020 оны 1 дүгээр улиралд цэвэр дүнгээр 35,684 сая ам.долларын үлдэгдэлтэй буюу өр төлбөртэй байна.

Монгол Улсын эдийн засгийн харьяатаас гадагш хийсэн хөрөнгө оруулалтын дүн (актив) 7,129 сая ам.доллар байна. Үүний 57%-ийг гадаад валютын албан нөөц, 29%-ийг бусад хөрөнгө оруулалтын актив, 9%-ийг шууд хөрөнгө оруулалт, 4%-ийг багцын хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна.

Харин Монгол Улсын эдийн засгийн харьяатад гадаадаас оруулсан хөрөнгө оруулалтын дүн (пассив) 42,813 сая ам.долларт хүрчээ. Үүний 54%-ийг гадаадын шууд хөрөнгө оруулалт, 35%-ийг бусад хөрөнгө оруулалт, үлдсэн 11%-ийг багцын хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна.

Гадаад хөрөнгө оруулалтын богино позиц өмнөх оны мөн үеэс 4%-аар буюу 1,300 сая ам.доллараар өссөн байна.

Үүнийг ерөнхий бүтцээр авч үзвэл: гадаад актив 9%-аар буюу 588 сая ам.доллараар, гадаад пассив 5%-аар буюу 1,888 сая ам.доллараар тус тус өссөн.


Харин дансаар нь авч үзвэл: гадаадын шууд хөрөнгө оруулалтын богино позиц 2,132 сая ам.доллар, бусад хөрөнгө оруулалтын богино позиц 260 сая ам.доллар, албан нөөц 434 сая ам.доллараар тус тус өссөн байна. Харин багцын хөрөнгө оруулалтын богино позиц 652 сая ам.доллараар буурсан байна.

Позицийн нийт өөрчлөлтийг авч үзвэл: төлбөрийн тэнцлийн урсгалаар -670 сая ам.доллар, ханшийн өөрчлөлтөөр -76 сая ам.доллар, бусад өөрчлөлтөөр 275 сая ам.доллар, үнийн өөрчлөлтөөр 618 сая ам.доллараар тус тус өөрчлөгджээ.

Хүснэгт 4. Позиц (сая ам.доллар)

Үзүүлэлт	3/31/2019	3/31/2020	Өөрчлөлт	
			дүн	хувь
Гадаад хөрөнгө оруулалтын позиц	-34,384	-35,684	1,300	4%
<b>I. Гадаад актив</b>	<b>6,541</b>	<b>7,129</b>	<b>588</b>	<b>9%</b>
1. Шууд хөрөнгө оруулалт	546	671	125	23%
2. Багцын хөрөнгө оруулалт	286	292	6	2%
3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	3	10	7	198%
4. Бусад хөрөнгө оруулалт	2,052	2,069	17	1%
5. Нөөц актив	3,653	4,087	434	12%
<b>II. Гадаад пассив</b>	<b>40,925</b>	<b>42,813</b>	<b>1,888</b>	<b>5%</b>
1. Шууд хөрөнгө оруулалт	20,674	22,931	2,257	11%
2. Багцын хөрөнгө оруулалт	5,392	4,746	-646	-12%
3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл	0	1	0	58%
4. Бусад хөрөнгө оруулалт	14,858	15,135	277	2%

Дүрслэл 11. Гадаад актив, пассив (сая ам.доллар)



### Шууд хөрөнгө оруулалт

Монгол Улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтын үлдэгдлийн 54%-ийг буюу 12,273 сая ам.долларыг хувь нийлүүлэгчийн дүрмийн сан дахь хөрөнгө оруулалт, үлдсэн 46% буюу 10,658 сая ам.долларыг толгой компаниасаа авсан зээл (компани хоорондын өглөг, санхүүжилт) эзэлж байна.

Манай улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтын үлдэгдлийг хөрөнгө оруулагч улсаар нь харуулбал:

- Канад улсаас 8,135 сая ам.доллар буюу нийт хөрөнгө оруулалтын 35%,
- БНХАУ-аас 5,077 сая ам.доллар буюу 22%,
- Сингапур улсаас 1,466 сая ам.доллар буюу 6%,
- Люксембург улсаас 1,478 сая ам.доллар буюу нийт хөрөнгө оруулалтын үлдэгдлийн 6%-ийг тус тус бүрдүүлж байна.

Дүрслэл 12. Шууд шууд хөрөнгө оруулалтын үлдэгдэл, 2020.1




### Багцын хөрөнгө оруулалт

Монгол Улсын багцын хөрөнгө оруулалтын гадаад активын үлдэгдэл 2020 оны 1 дүгээр улиралд 292 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 2%-аар өссөн бол гадаад пассивын үлдэгдэл 4,746 сая ам.долларт хүрч, 12%-аар буурсан үзүүлэлттэй байна.

**Актив:** манай эдийн засгийн харьяатуудын эзэмшиж буй үнэт цаасыг гаргасан улсаар нь авч үзвэл: Хонг-Конг 31%, АНУ 14%, Сингапур 12%, Австрали 7%, Их Британ 6%-ийг тус тус эзэлж байна.

**Пассив:** Монголын эдийн засгийн харьяатуудын гаргасан үнэт цаасыг эзэмшигч улсаар нь ангилбал: АНУ 24%, Их Британ 11%, Люксембург 6%, Сингапур 4%, Герман 3%, үлдсэн 33% нь хоёрдогч зах зээл дээр арилжаалагдаж байгаа тул хөрөнгө оруулагчийн харьяалах улсыг тодорхойлох боломжгүй байна.

Дүрслэл 13. Багцын ХО-ын үлдэгдэл, 2020.I (сая ам.доллар)



### 3. Гадаад өрийн статистик

Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 2020 оны 1 дүгээр улирлын эцсийн байдлаар 30,461 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеийн гүйцэтгэлээс 939 сая ам.доллараар өссөн байна.

**Улсын салбар:** Засгийн газрын гадаад өр 26 сая ам.доллараар буурч 7,236 сая ам.долларт, Монголбанкны гадаад өр 99 сая ам.доллараар буурч, 1,973 сая ам.долларт хүрчээ.

**Бусад салбар:** Банк, бусад секторын болон хөрөнгө оруулагчийн зээлийг бүхэлд нь хувийн хэвшлийн салбарын гадаад өр гэж ойлгох бөгөөд энэ дүн өнгөрсөн оны мөн үеэс 1,065 сая ам.доллараар өсч 21,252 сая ам.долларт хүрээд байна.

Хүснэгт 5. Нийт гадаад өрийн үлдэгдэл (сая ам.доллар).

Үзүүлэлт	3/31/2019	3/31/2020	Өөрчлөлт		* %
			дүн	хувь	
<b>Нийт гадаад өр</b>	<b>29,522</b>	<b>30,461</b>	<b>939</b>	<b>3%</b>	<b>100%</b>
<b>I. Засгийн газар</b>	<b>7,262</b>	<b>7,236</b>	<b>-26</b>	<b>0%</b>	<b>24%</b>
Бонд, өрийн бичиг	2,970	2,488	-482	-16%	
Зээл	4,293	4,748	455	11%	
<b>II. Төв банк</b>	<b>2,072</b>	<b>1,973</b>	<b>-99</b>	<b>-5%</b>	<b>6%</b>
<b>III. Банк</b>	<b>2,393</b>	<b>2,212</b>	<b>-181</b>	<b>-8%</b>	<b>7%</b>
Богино хугацаат	780	626	-154	-20%	2%
Урт хугацаат	1,613	1,586	-27	-2%	5%
<b>IV. Бусад сектор</b>	<b>8,385</b>	<b>8,381</b>	<b>-4</b>	<b>0%</b>	<b>28%</b>
Богино хугацаат	630	622	-8	-1%	2%
Урт хугацаат	7,755	7,759	4	0%	25%
<b>V. Хөрөнгө оруулагчаас авсан зээл</b>	<b>9,409</b>	<b>10,658</b>	<b>1,249</b>	<b>13%</b>	<b>35%</b>

\*: Нийт өсөлтөд оруулсан хувь


### Банкны салбар

Банкны салбарын гадаад өр төлбөрийн үлдэгдэл 2020 оны 1 дүгээр улирлын эцэст 2,212 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 181 сая ам.доллараар буурчээ.

Гадаад өрийн 44%-ийг урт хугацаат зээл, 28%-ийг бонд өрийн бичиг, 13%-ийг богино хугацаат зээл, үлдсэн 15%-ийг эдийн засгийн харьяат бусын эзэмшиж буй харилцах, хадгаламжийн дансны өглөг тус тус бүрдүүлж байна.

Банкуудын урт болон богино хугацаат арилжааны зээлийн үлдэгдэл харгалзан 965 сая ам.доллар, 298 сая ам.долларт хүрэв.

Дүрслэл 14. Банкны салбарын гадаад өр (сая ам.доллар)



### Банкнаас бусад салбар

Банкнаас бусад салбарын буюу аж ахуйн нэгж, иргэдийн гадаад өр төлбөр 2020 оны 1 дүгээр улирлын эцэст 19,039 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оноос 1,246 сая ам.доллараар өссөн дүнтэй байна.


Салбарын нийт зээлийн 56% буюу 10,334 сая ам.долларын эх үүсвэр нь аж ахуйн нэгж, байгууллагуудын гадаадын хөрөнгө оруулагчдаасаа авсан зээл буюу компани хоорондын өглөг бөгөөд үүний дийлэнх нь уул уурхайн салбарт ашиглагдсан байна.

Хөрөнгө оруулагчдаас авсан зээлийн эх үүсвэр нь компанийн эргэлтийн хөрөнгө, мөнгөн урсгалыг дэмжих зорилгоор олгогддог урт хугацаат санхүүжилт бөгөөд ихэнх тохиолдолд хүүгүй, хатуу мөрдөх эргэн төлөлтийн хуваарь байхгүй, харилцан тохиролцсоны үндсэн дээр цаашид дүрмийн санд нэмж тооцогдох боломжтой байдгаараа

бусад төрлийн зээлийн санхүүжилтээс ялгаатай байдаг.

Эдийн засгийн харьяат аж ахуйн нэгжүүдийн гадаадаас хүлээн авсан экспортын барааны урьдчилгаа, төлбөрийг хийгээгүй боловч хүлээн авсан импортын барааны төлбөрийн үлдэгдэл тайлант улирлын эцсийн байдлаар 380 сая ам.доллар болсон байна.

Дүрслэл 15. Бусад салбарын гадаад өр (сая ам.доллар)



Мэдээллийн эх сурвалж:

1. Засгийн газар: Сангийн яам, Өрийн удирдлагын хэлтэс
2. Монголбанк: ТТБГазар, ССГазар
3. Банк: Банкуудын тайлан тэнцэл, төлбөрийн тэнцлийн сарын мэдээ, гадаад зээлийн бүртгэл
4. Бусад салбар: ААН-ийн Төлбөрийн тэнцлийн улирлын мэдээ, гадаад зээлийн бүртгэлийн мэдээллийг тус тус ашиглав.



ХАВСРАЛТ 1. МОНГОЛ УЛСЫН ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН ХУРААНГУЙ ХҮСНЭГТ (сая ам.доллар)

Үзүүлэлт	Гуулрал			Өөрчлөлт		Өөрчлөлт	
	2018	2019	2020	Дүн	2019/18	Дүн	2020/19
<b>I. УРСГАЛ ДАНС</b>	<b>-441</b>	<b>-398</b>	<b>-669</b>	<b>43</b>	<b>10%</b>	<b>-271</b>	<b>-68%</b>
<b>Бараа ба үйлчилгээний худалдаа</b>	<b>-308</b>	<b>-183</b>	<b>-584</b>	<b>125</b>	<b>41%</b>	<b>-402</b>	<b>-220%</b>
Кредит	1,560	1,885	1,034	325	21%	-851	-45%
Дебет	1,868	2,068	1,618	200	11%	-449	-22%
<b>1. Бараа</b>	<b>239</b>	<b>464</b>	<b>-277</b>	<b>226</b>	<b>95%</b>	<b>-741</b>	<b>-160%</b>
1.1 Экспорт Ф.О.Б (кредит)	1,371	1,697	861	326	24%	-835	-49%
1.2 Импорт Ф.О.Б (дебит)	1,132	1,232	1,138	100	9%	-94	-8%
<b>2. Үйлчилгээ</b>	<b>-547</b>	<b>-647</b>	<b>-308</b>	<b>-100</b>	<b>-18%</b>	<b>339</b>	<b>52%</b>
Кредит	189	188	173	-1	0%	-16	-8%
Дебет	736	835	480	100	14%	-355	-42%
2.1 Тээвэр	-109	-135	-31	-26	-24%	104	77%
Кредит	76	67	102	-9	-12%	35	51%
Дебет	185	203	133	17	9%	-70	-34%
2.2 Аялал	-199	-192	-175	7	3%	17	9%
Кредит	43	48	20	6	13%	-28	-58%
Дебет	241	240	195	-1	0%	-45	-19%
2.3 Бусад үйлчилгээ	-239	-320	-101	-81	-34%	218	68%
Кредит	70	73	51	3	4%	-22	-30%
Дебет	309	392	152	84	27%	-240	-61%
<b>3 Анхдагч орлого</b>	<b>-213</b>	<b>-289</b>	<b>-163</b>	<b>-76</b>	<b>-36%</b>	<b>125</b>	<b>43%</b>
Кредит	81	93	91	13	16%	-2	-2%
Дебет	294	382	255	88	30%	-127	-33%
3.1 Ажилчдын цалин	45	58	56	13	28%	-2	-3%
3.2 Хөрөнгө оруулалтын орлого	-260	-349	-223	-89	-34%	127	36%
3.3 Бусад	2	3	3	1	30%	0	13%
<b>4 Хоёрдогч орлого</b>	<b>80</b>	<b>73</b>	<b>79</b>	<b>-7</b>	<b>-8%</b>	<b>5</b>	<b>7%</b>
Кредит	112	105	110	-7	-6%	4	4%
Дебит	32	32	31	0	-1%	-1	-3%
Үүнээс: Хувийн гуйвуулга	38	37	43	-1	-3%	6	17%
<b>II. ХӨРӨНГИЙН ДАНС</b>	<b>15</b>	<b>25</b>	<b>18</b>	<b>10</b>	<b>64%</b>	<b>-7</b>	<b>-28%</b>
<b>1. Үйлдвэрлэхгүй санхүүгийн бус хөрөнгийн өсөлт/бууралт</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>		<b>0</b>	
Кредит	0	0	0	0		0	
Дебет	0	0	0	0		0	
<b>2. Хөрөнгийн шилжүүлэг</b>	<b>15</b>	<b>25</b>	<b>18</b>	<b>10</b>	<b>64%</b>	<b>-7</b>	<b>-28%</b>
Кредит	15	25	19	10	64%	-7	-26%
Дебет	0	0	1	0	85%	0	100%
<b>Урсгал болон Хөрөнгийн дансны тэнцэл (зээлдүүлэг + / зээлдэг -)</b>	<b>-426</b>	<b>-373</b>	<b>-651</b>	<b>52</b>	<b>12%</b>	<b>-278</b>	<b>-74%</b>
<b>III. САНХҮҮГИЙН ДАНС</b>	<b>-298</b>	<b>-558</b>	<b>-320</b>	<b>-260</b>	<b>-87%</b>	<b>237</b>	<b>43%</b>
<b>Санхүүгийн дансны тэнцэл (зээлдүүлэг + / зээлдэг -)</b>	<b>-298</b>	<b>-558</b>	<b>-320</b>	<b>-260</b>	<b>-87%</b>	<b>237</b>	<b>43%</b>
<b>1. Шууд хөрөнгө оруулалт</b>	<b>-478</b>	<b>-482</b>	<b>-367</b>	<b>-4</b>	<b>-1%</b>	<b>115</b>	<b>24%</b>
1.1 Актив	24	10	10	-15	-61%	1	6%
1.1.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	20	8	14	-12	-59%	6	68%
1.1.2 Өрийн хэргэсэл	4	1	-4	-3	-66%	-5	-389%
1.2 Пассив	502	491	377	-11	-2%	-114	-23%
1.2.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	272	311	87	38	14%	-224	-72%
1.2.2 Өрийн хэргэсэл	230	181	290	-49	-21%	109	60%
<b>2. Багцын хөрөнгө оруулалт</b>	<b>162</b>	<b>-341</b>	<b>-51</b>	<b>-504</b>	<b>-311%</b>	<b>291</b>	<b>85%</b>
2.1 Актив	14	-1	9	-15	-105%	10	1456%
2.1.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	14	1	9	-13	-93%	8	862%
2.1.2 Өрийн бичиг	0	-2	0	-2	-27044%	2	120%
2.2 Пассив	-148	341	60	489	330%	-281	-82%
2.2.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	-8	0	2	8	98%	2	1233%
2.2.2 Өрийн бичиг	-140	341	58	481	343%	-283	-83%
<b>3. Санхүүгийн үүсгэл хэргэслүүд</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>5%</b>	<b>1</b>	<b>130%</b>
3.1 Актив	6	-1	1	-6	-110%	1	257%
3.2 Пассив	6	0	1	-6	-102%	1	853%
<b>4. Бусад хөрөнгө оруулалт</b>	<b>19</b>	<b>266</b>	<b>97</b>	<b>247</b>	<b>1299%</b>	<b>-169</b>	<b>-63%</b>
4.1 Актив	71	263	237	192	269%	-26	-10%
4.1.1 Бусад хөрөнгө	0	0	0	0		0	
4.1.2 Бэлэн мөнгө ба харилцах	157	232	235	76	48%	3	1%
4.1.3 Зээл	-6	6	33	12	206%	27	429%
4.1.4 Даатгал, тэтгэвэр болон стандарт баталгааны систем	0	0	0	0		0	
4.1.5 Худалдааны зээл ба урьдчилгаа	-80	25	-31	104	131%	-55	-225%
4.1.5 Бусад авлага	0	0	0	0		0	
4.2 Пассив	-52	-3	140	-55	-106%	143	4757%
4.2.1 Бусад хөрөнгө	0	0	0	0		0	
4.2.2 Бэлэн мөнгө ба харилцах	18	30	9	12	64%	-21	-69%
4.2.3 Зээл	57	40	70	-17	-30%	30	74%
4.2.3.1 Төв банк	0	0	0	0		0	
4.2.3.3 Хадгаламжийн байгууллагууд	81	39	42	-42	-52%	3	8%
4.2.3.3.1 Богино хугацаат	65	-25	1	-89	-138%	26	106%
4.2.3.3.2 Урт хугацаат	16	64	41	48	298%	-23	-36%
4.2.3.2 Засгийн газар	28	62	75	34	123%	13	22%
4.2.3.4 Бусад салбар	-52	-61	-47	-9	-18%	13	22%
4.2.4 Даатгал, тэтгэвэр болон стандарт баталгааны систем	0	0	0	0		0	
4.2.5 Худалдааны зээл ба урьдчилгаа	-23	-73	61	-50	-218%	134	184%
4.2.6 Бусад авлага	0	0	0	0		0	
4.2.7 Зээлжих тусгай эрх	0	0	0	0		0	
<b>Төлбөрийн тэнцлийн нийт дүн</b>	<b>-42</b>	<b>220</b>	<b>-350</b>	<b>262</b>	<b>620%</b>	<b>-570</b>	<b>-259%</b>
<b>V. НӨӨЦ ХӨРӨНГӨ</b>	<b>-42</b>	<b>220</b>	<b>-350</b>	<b>262</b>	<b>620%</b>	<b>-570</b>	<b>-259%</b>
1. ГВУН	-12	220	-350	231		-570	
2. ОУВС-гийн зээл	31	0	0	-31		0	
3. Тусгай санхүүжилт	0	0	0	0		0	

\* [-] утга нь өсөлтийг, [+] утга нь бууралтыг тус тус илэрхийлнэ.

ХАВСРАЛТ 2. ГАДААД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ПОЗИЦИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН (сая ам.доллар)

Үзүүлэлт	03/31/2019	6/30/2019	9/30/2019	12/31/2019	3/31/2020
<b>Гадаад хөрөнгө оруулалтын нэвэрлэлт</b>	<b>(34,384)</b>	<b>(34,501)</b>	<b>(34,795)</b>	<b>(35,831)</b>	<b>(35,684)</b>
<b>Актив</b>	<b>6,541</b>	<b>6,874</b>	<b>6,964</b>	<b>7,140</b>	<b>7,129</b>
<b>Шууд хөрөнгө оруулалт</b>	<b>546</b>	<b>565</b>	<b>584</b>	<b>665</b>	<b>671</b>
Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	478	497	515	556	566
Шууд хөрөнгө оруулалттай компанид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулагч	478	497	515	556	566
Шууд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулалттай компани (урвуу хөрөнгө оруулалт)	0	0	0	0	0
Хамааралтай компани хоорондын	0	0	0	0	0
<b>Орийн хэргээс</b>	<b>68</b>	<b>69</b>	<b>68</b>	<b>109</b>	<b>105</b>
Шууд хөрөнгө оруулалттай компанид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулагч	68	68	68	108	104
Шууд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулалттай компани (урвуу хөрөнгө оруулалт)	1	1	1	1	1
Хамааралтай компани хоорондын	0	0	0	0	0
<b>Багцын хөрөнгө оруулалт</b>	<b>286</b>	<b>288</b>	<b>286</b>	<b>284</b>	<b>292</b>
Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх	269	262	262	255	263
Төв банк	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	22	23	22	22	22
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0
Бусад салбарууд	247	240	240	233	242
Бусад санхүүгийн байгууллага	211	214	216	218	227
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	36	26	25	15	15
Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхээс бусад хөрөнгийн үнэт цаас	0	0	0	0	0
Хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа/ нэгж эрх	0	0	0	0	0
<b>Орийн бичиг</b>	<b>18</b>	<b>25</b>	<b>24</b>	<b>29</b>	<b>29</b>
Төв банк	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	7	9	6	6	6
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0
Бусад салбарууд	10	16	17	23	23
Бусад санхүүгийн байгууллага	10	10	10	10	10
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	0	6	7	12	12
<b>Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (нөөцөөс бусад) ба ажигчдын хувьцааны опцион</b>	<b>3</b>	<b>6</b>	<b>5</b>	<b>9</b>	<b>10</b>
Төв банк	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад)	0	0	0	1	0
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0
Бусад салбарууд	3	5	4	9	10
Бусад санхүүгийн байгууллагууд	3	5	4	9	10
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	0	0	0	0	0
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (нөөцөөс бусад)	0	0	0	0	0
Опцион	0	0	0	0	0
Форвард хэлбэрийн хэлцлүүд	0	0	0	0	0
Ажилчдын хувьцааны опцион	0	0	0	0	0
<b>Бусад хөрөнгө оруулалт</b>	<b>2,052</b>	<b>1,921</b>	<b>2,112</b>	<b>1,841</b>	<b>2,069</b>
<b>Бусад хөрөнгө</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>
<b>Бэлэн мөнгө ба харилцах</b>	<b>1,520</b>	<b>1,402</b>	<b>1,541</b>	<b>1,324</b>	<b>1,549</b>
Төв банк	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад)	808	665	873	582	743
үүнээс: Банк хоорондын позиц	0	0	0	0	0
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0
Бусад салбарууд	712	737	668	742	806
Бусад санхүүгийн байгууллага	0	13	27	2	2
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	712	724	641	740	804
<b>Зээл</b>	<b>156</b>	<b>156</b>	<b>156</b>	<b>145</b>	<b>178</b>
Төв банк	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад)	156	156	156	145	145
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0
Бусад салбарууд	0	0	0	0	33
Даатгал, тэтгэвэр болон стандарт баталгааны систем (F60)	0	0	0	0	0
Худалдааны зээл ба урьдчилгаа	376	364	416	372	341
Бусад дансны авлага/өглөг	0	0	0	0	0
<b>Ноц хөрөнгө</b>	<b>3,653</b>	<b>4,094</b>	<b>3,978</b>	<b>4,341</b>	<b>4,087</b>

Үзүүлэлт	03/31/2019	6/30/2019	9/30/2019	12/31/2019	3/31/2020
<b>Гадаад пассив</b>	<b>40,925</b>	<b>41,375</b>	<b>41,759</b>	<b>42,971</b>	<b>42,813</b>
<b>Шууд хөрөнгө оруулалт</b>	<b>20,674</b>	<b>21,230</b>	<b>21,687</b>	<b>22,556</b>	<b>22,931</b>
<b>Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх</b>	<b>11,304</b>	<b>11,583</b>	<b>11,864</b>	<b>12,189</b>	<b>12,273</b>
Шууд хөрөнгө оруулалттай компанид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулагч	11,304	11,583	11,864	12,189	12,273
Шууд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулалттай компани (урвуу хөрөнгө оруулалт)	0	0	0	0	0
Хамааралтай компани хоорондын	0	0	0	0	0
<b>Өрийн хэргэсэл</b>	<b>9,370</b>	<b>9,647</b>	<b>9,822</b>	<b>10,366</b>	<b>10,658</b>
Шууд хөрөнгө оруулалттай компанид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулагч	9,370	9,647	9,822	10,366	10,658
Шууд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулалттай компани (урвуу хөрөнгө оруулалт)	0	0	0	0	0
Хамааралтай компани хоорондын	0	0	0	0	0
<b>Багцын хөрөнгө оруулалт</b>	<b>5,392</b>	<b>5,431</b>	<b>5,412</b>	<b>5,430</b>	<b>4,746</b>
<b>Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх</b>	<b>74</b>	<b>77</b>	<b>78</b>	<b>79</b>	<b>79</b>
Төв банк	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	21	20	20	20	20
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0
Бусад салбарууд	53	57	58	59	59
Бусад санхүүгийн байгууллага	21	25	26	26	24
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	32	31	32	33	35
Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхээс бусад хөрөнгийн үнэт цаас	0	0	0	0	0
Хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа/ нэгж эрх	0	0	0	0	0
<b>Өрийн бичиг</b>	<b>5,318</b>	<b>5,354</b>	<b>5,334</b>	<b>5,351</b>	<b>4,667</b>
Төв банк	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	631	622	627	609	622
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	3,117	3,107	3,095	3,123	2,488
Бусад салбарууд	1,569	1,625	1,612	1,619	1,558
Бусад санхүүгийн байгууллага	1,126	1,124	1,123	1,118	1,039
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	443	501	489	501	519
<b>Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (нөөцөөс бусад) ба ажилчдын хувьцааны опцион</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>1</b>
Төв банк	0	0	0	0	0
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад)	0	0	0	0	0
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0
Бусад салбарууд	0	0	0	0	0
Бусад санхүүгийн байгууллагууд	0	0	0	0	0
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	0	0	0	0	0
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (нөөцөөс бусад)	0	0	0	0	0
Опцион	0	0	0	0	0
Форвард хэлбэрийн хэлцлүүд	0	0	0	0	0
Ажилчдын хувьцааны опцион	0	0	0	0	0
<b>Бусад хөрөнгө оруулалт</b>	<b>14,858</b>	<b>14,714</b>	<b>14,660</b>	<b>14,985</b>	<b>15,135</b>
<b>Бусад хөрөнгө</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>
<b>Бэлэн мөнгө ба харилцах</b>	<b>2,194</b>	<b>2,081</b>	<b>2,012</b>	<b>2,039</b>	<b>2,020</b>
Төв банк	1,786	1,747	1,683	1,717	1,692
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад)	397	334	329	322	328
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	0	0	0	0	0
Бусад салбарууд	11	0	0	0	0
Бусад санхүүгийн байгууллага	11	0	0	0	0
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	0	0	0	0	0
<b>Зээл</b>	<b>12,404</b>	<b>12,341</b>	<b>12,375</b>	<b>12,629</b>	<b>12,736</b>
Төв банк	287	286	265	268	281
Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол)	0	0	0	0	0
Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад)	1,352	1,274	1,250	1,207	1,263
Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага)	4,307	4,341	4,335	4,683	4,748
Бусад салбарууд	6,459	6,439	6,526	6,471	6,444
Бусад санхүүгийн байгууллага	300	322	415	428	406
Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага	6,159	6,117	6,111	6,042	6,038
<b>Даатгал, тэтгэвэр болон стандарт баталгааны систем (F60)</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>
Худалдааны зээл ба урьдчилгаа	260	292	273	318	379
<b>Бусад дансны авлага/өглөг</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>0</b>

ХАВСРАЛТ 3. МОНГОЛ УЛСЫН ГАДААД ӨР (сая ам.доллар)

Үзүүлэлт	12/31/2016	12/31/2017	12/31/2018	12/31/2019	3/31/2020
<b>Засгийн газар</b>	<b>4,869</b>	<b>7,321</b>	<b>7,184</b>	<b>7,806</b>	<b>7,236</b>
<b>Богино хугацаат</b>	-	-	-	-	-
Харилцах, хадгаламж 5/	-	-	-	-	-
Өрийн бичиг 4/	-	-	-	-	-
Зээл	-	-	-	-	-
Худалдааны зээл болон урьдчилгаа	-	-	-	-	-
Бусад өглөг 6/	-	-	-	-	-
<b>Урт хугацаат</b>	<b>4,869</b>	<b>7,321</b>	<b>7,184</b>	<b>7,806</b>	<b>7,236</b>
Зээлжих тусгай эрх ЗТЭ-ийн хуваарилалт 7/	-	-	-	-	-
Харилцах, хадгаламж 5/	-	-	-	-	-
Өрийн бичиг 4/	2,064	3,549	2,946	3,123	2,488
Зээл	2,805	3,772	4,238	4,683	4,748
Худалдааны зээл болон урьдчилгаа	-	-	-	-	-
Бусад өглөг 6/	-	-	-	-	-
<b>Төвбанк</b>	<b>1,791</b>	<b>2,025</b>	<b>2,030</b>	<b>1,985</b>	<b>1,973</b>
<b>Богино хугацаат</b>	<b>1,725</b>	<b>1,837</b>	<b>1,745</b>	<b>1,717</b>	<b>1,692</b>
Харилцах, хадгаламж 5/	1,725	1,837	1,745	1,717	1,692
Өрийн бичиг 4/	-	-	-	-	-
Зээл	-	-	-	-	-
Худалдааны зээл болон урьдчилгаа	-	-	-	-	-
Бусад өглөг 6/	-	-	-	-	-
<b>Урт хугацаат</b>	<b>65</b>	<b>188</b>	<b>286</b>	<b>268</b>	<b>281</b>
Зээлжих тусгай эрх ЗТЭ-ийн хуваарилалт 7/	65	188	286	268	281
Харилцах, хадгаламж 5/	-	-	-	-	-
Өрийн бичиг 4/	-	-	-	-	-
Зээл	-	-	-	-	-
Худалдааны зээл болон урьдчилгаа	-	-	-	-	-
Бусад өглөг 6/	-	-	-	-	-
<b>Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)</b>	<b>2,417</b>	<b>2,194</b>	<b>2,230</b>	<b>2,138</b>	<b>2,212</b>
<b>Богино хугацаат</b>	<b>469</b>	<b>659</b>	<b>764</b>	<b>610</b>	<b>626</b>
Харилцах, хадгаламж 5/	-	314	327	322	328
Өрийн бичиг 4/	-	-	-	-	-
Зээл	469	345	437	288	298
Худалдааны зээл болон урьдчилгаа	-	-	-	-	-
Бусад өглөг 6/	-	-	-	-	-
<b>Урт хугацаат</b>	<b>1,948</b>	<b>1,535</b>	<b>1,466</b>	<b>1,528</b>	<b>1,586</b>
Харилцах, хадгаламж 5/	240	-	-	-	-
Өрийн бичиг 4/	611	589	624	609	622
Зээл	1,098	946	842	919	965
Худалдааны зээл болон урьдчилгаа	-	-	-	-	-
Бусад өглөг 6/	-	-	-	-	-
<b>Бусад салбарууд</b>	<b>8,121</b>	<b>7,956</b>	<b>8,042</b>	<b>8,407</b>	<b>8,381</b>
<b>Богино хугацаат</b>	<b>394</b>	<b>666</b>	<b>609</b>	<b>562</b>	<b>622</b>
Харилцах, хадгаламж 5/	-	95	51	-	-
Өрийн бичиг 4/	2	2	2	2	2
Зээл	218	292	275	262	261
Худалдааны зээл болон урьдчилгаа	175	277	281	298	359
Бусад өглөг 6/	-	-	-	-	-
<b>Урт хугацаат</b>	<b>7,727</b>	<b>7,289</b>	<b>7,433</b>	<b>7,845</b>	<b>7,759</b>
Харилцах, хадгаламж 5/	-	-	-	-	-
Өрийн бичиг 4/	884	726	1,239	1,617	1,556
Зээл	6,802	6,560	6,187	6,208	6,183
Худалдааны зээл болон урьдчилгаа	41	3	7	20	20
Бусад өглөг 6/	-	-	-	-	-
<b>Шууд хөрөнгө оруулалт: Компани хоорондын зээллэг</b>	<b>7,426</b>	<b>7,996</b>	<b>9,228</b>	<b>10,366</b>	<b>10,658</b>
Шууд хөрөнгө оруулагчид өгөх өглөг	7,426	7,996	9,228	10,366	10,658
Шууд хөрөнгө оруулагчийн өгөх өглөг	-	-	-	-	-
Хамааралтай компани хоорондын өглөг	-	-	-	-	-
<b>Нийт гадаад өр</b>	<b>24,625</b>	<b>27,493</b>	<b>28,715</b>	<b>30,702</b>	<b>30,461</b>